



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 238

Улаанбаатар хот

□ **Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай** □

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.3, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 421,094,932.99 (дөрвөн зуун хорин нэгэн сая ерэн дөрвөн мянга есөн зуун гучин хоёр төгрөг ерэн есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын газрын дарга Б.Азжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталсан барилга, байгууламжийн доорх Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Номгон багт байрлах 2689 м.кв газрыг зориулалтаар нь ашиглах, төрийн байгууллагын мэдэлд хэвээр үлдээх, Нийгмийн даатгалын газрын албан конторын барилга барих, нөхөн сэргээх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000802
10-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2025 оны 03 дугаар сарын 04 өдрийн
 238 дугаар тогтоолын хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН-ГАЗРЫН
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын газрын конторын барилга /Баянхонгор аймаг, Баянхогор сум Номгон баг/	1982	1	420,371,632.31	420,371,632.31	-
2	Модон хашаа	2004	1	723,300.68	723,300.68	-
				421,094,932.99	421,094,932.99	-
	Нийт дүн		2	(дөрвөн зуун хорин нэгэн сая ерэн дөрвөн мянга есөн зуун гучин хоёр төгрөг ерэн есөн мөнгө)	(дөрвөн зуун хорин нэгэн сая ерэн дөрвөн мянга есөн зуун гучин хоёр төгрөг ерэн есөн мөнгө)	